



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 09 сарын 04 өдөр

Дугаар А/531

Есөнбулаг

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1 дэх хэсэг, 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй 15.6 км хатуу хучилттай автозамын трасс дагуух объектыг чөлөөлж, төсөл арга хэмжээг саадгүй явуулах нөхцөлийг бүрдүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:	Д.Батбилэг	(Аймгийн Засаг даргын хөгжлийн бодлого хариуцсан орлогч)
Гишүүдэд:	Д.Алтанзагас	(Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч) (зөвшилцсөнөөр)
	Г.Мөнхөө	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын автозамын гэрээт ажилтан)
	А.Алтанхуяг	(Есөнбулаг сумын Засаг дарга)
	Д.Гаадамба	(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
	Б.Бямбадорж	(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга бөгөөд аймгийн ерөнхий архитектор)
	А.Пүрэвсэд	(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын газар зохион байгуулалт, төлөвлөлт, газар өмчлөлийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн)
	Г.Болд-Эрдэнэ	(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын геодези, зураг зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн)
	А.Оюун-Эрдэнэ	(Газар, геодези, зураг зүйн хяналтын улсын байцаагч)
Нарийн бичгийн дарга:	Б.Бадамлянхуа	(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Есөнбулаг сумын газрын даамал)

2.

2.Газар чөлөөлөлтийг магадлалаар батлагдсан зураг төслийн трасс дагуу өртсөн хашаа, объектыг 2024 оны 12 дугаар сарын 30-ны дотор чөлөөлж, үр дүнг танилцуулахыг ажлын хэсэг (Д.Батбилэг)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ